

ДеФакто **ТОЙМ**

➤ ЗАХИРГААНЫ  
ЕРӨНХИЙ ХУУЛИЙН  
ХОРИГ

➤ НАЙРАМДАЛ  
ЗУСЛАНГИЙН ГАЗАРТ  
“НАЙРЛАСАН” НЬ

VII НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан  
Эдийн засагч, нийтлэлч

ОЮУ ТОЛГОЙ  
**АЛЦАА**  
БОЛСОН УУ?

II НҮҮРТ



**БОЛОВСРОЛ**

Б.Насанбаяр  
Ph.D /Боловсрол судлал/

Хүчдгийн хөгжилд  
**ЭЦЭГ, ЭХ БИД...**

V НҮҮРТ

WEEKLY

# The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ


ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Баасан, 2019.06.07, №8 (100)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,  
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

[www.defacto.mn](http://www.defacto.mn)



Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,  
<http://jargaldefacto.com/category/23>

# ОЮУ АЛДАА БОЛСОН УУ?

## ТОЛГОЙ

**Ө**нгөрсөн ням гарагт (190602) орон даяар хамгийн олон үзэгчтэй МҮОНТ-ийн долоо хоногийн тоймоор Оюу толгой (ОТ) төсөл нь алдаа болсон, харилцан ашигтай биш. Бид алдаанаасаа туршлага, сургамжтай үлдлээ гэв. Энэ том төслийг хоёр сарын турш шалгасан УИХ-ын 12 гишүүнтэй ажлын хэсгийн тайланг Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцсэнийг сурвалжлан танилцуулаад ийм дүгнэлт хийжээ.

Алдсан ч, оносон ч эдүгээ монголын эдийн засгийн нуруундаа үүрэлцэж яваа энэ мега төслийн тухай иймэрхүү дүгнэлт газар авч, нийгэм ОТ төсөлд сөргөөр хандах нь давамгайлсаар байна. Гэхдээ эерэг сөргийн ялгаа 2015 оныг 2019 онтой харьцуулбал тогтмол

буурсныг Q-score гэдэг судалгаа харуулж байна. Яг ямар асуудлаар монголын төр засаг ба хөрөнгө оруулагч нарын хооронд зөрөлдөөн гараад байгааг иргэд бодитоор харж тунгаан бодох шаардлага тулгарлаа.

Монголын иргэд ОТ-ын талаар ойлголтоо цэгцэлж, тодорхой байр суурин дээр нэгдэхгүй бол сонгуулийн синдромын нөлөөгөөр энэ төсөл зогсож, хөрөнгө оруулагчид монголоос гарч явах магадлал өндөр боллоо. Төсөвтэй нөхцөл байдалд, Рио Тинто нэг жилийн өмнө дэлхийд нөөцөөрөө хоёрт жагсдаг, 40 хувийг нь эзэмшиж байсан Индонезийн Грасбергийн зэсийн орд газраас гарсан билээ.

## ТӨСЛИЙН БОДИТ БАЙДАЛ

Монгол улс ба гадаадын хөрөнгө оруулагчид 32 сая тонн зэсийн олборлох нөөцөөрөө дэлхийд гуравт орж буй Оюу толгойн орд газрыг ашиглах гэрээг зураад яг 10 жил болж байна. Орд газрыг монголын Засгийн газар 34, АНУ, Канадын хөрөнгийн биржид бүртгэлтэй Туркойз Хилл Ресурс компани 66 хувийг нь эзэмшиж байна. Туркойз Хилл Ресурсын 51 хувь нь дэлхийн хоёр дахь том уул уурхайн компани Рио Тинтод очсоноор ОТ ордыг олборлох боломж ийнхүү бүрдэв. ОТ-н нөөцийн 20 хувь нь ил, 80 хувь нь газрын гүнд 700-1300 метрийн дор оршдог.

Ил уурхайг нь олборлон 2013 оноос зэсийн баяжмал экспортолж эхэлсэн, далд уурхайгаа 2016 оноос ашиглалтад бэлдэж, 2021-2022 оноос олборлолт эхлүүлэх ажээ. Эдүгээ ОТ төсөлд нийт 12 орчим тэрбум долларын санхүүжилт, 3 нь хувьцааны буюу өөрийн хөрөнгөөр, 6 нь гадаадын 15 том банкны зээлээр, 4 нь төслийн санхүүжилтээс бүрдээд байна гэж дээрх УИХ-ын Ажлын хэсгийн тайланд оржээ.

**ОТ компани 2014 онд 1.8; 2015 онд 1.6; 2017 онд 0.94; 2018 онд 1.2 тэрбум доллар буюу нийт 5.6 тэрбум долларын борлуулалтыг олборлолт эхэлснээс хойш хийгээд байна. Энэ нь 18 тэрбум доллар одоогоор энэ компанид орсон гэсэн үг.**

Тэгвэл монголын ДНБ-ээс том энэ мөнгөний хагас нь буюу 9.1 тэрбум доллар нь монголын эдийн засагт шингэжээ. ОТ компанийн мэдээлснээр үүний 6 хувь нь үндсэн болон гэрээт ажилчдын цалинд, 19 хувь нь төрийн байгууллагуудад татвар, хураамж, төлбөр хэлбэрээр, 75 хувь нь монголын 800 гаруй ханган нийлүүлэгч компаниудаас авсан бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрт явжээ. Нөгөө хагас нь тоног төхөөрөмж зэрэг үндсэн болон эргэлтийн хөрөнгө худалдан авах, менежмент болон захиргааны, бусад зардалд явжээ.





ОТ компани хөрөнгө оруулалтаа 2029 он хүртэл нөхөж чадахгүй, нөхсөнөөс хойш 10 жилийн турш монголын Засгийн газар зээлж бүрдүүлсэн өөрийн

“Оюу толгой”-н 2019 оны  
I улирлын тойм мэдээ

# МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2019 оны 4 дүгээр сар

“Оюу толгой” компани үйл ажиллагаагаа аюул ослоос ангид тогтвортой явуулж, оролцогч талуудад үр өгөөжөө өгөх үүрэг хүлээсэн билээ. Энэхүү үнэлгээний хуудсаар дамжуулан бид аюулгүй ажиллагаа, байгаль орчин, худалдан авалт, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөрөнгө оруулалт зэрэг үндсэн чиглэлээр олж буй ахиц дэвшлийн талаарх мэдээллийг хүргэх болно.



▶ хөрөнгийн (1.07 тэрбум доллар) төлбөрөө хүүтэй нь (2019 оны байдлаар 541 сая доллар) төлж барагдуулаад 2040 оноос л ногдол ашиг авна гэж Эрдэнэс ОТ компани мэдээлжээ.

Эдүгээ далд уурхайн бэлтгэл ажил ид явагдаж, 16 мянга гаруй хүн ажиллаж байгаагаас 93 хувь нь монголчууд ажээ. Гэхдээ 2023 оноос олборлолт эхлээд ажил жигдрэхээр Оюу толгойн уурхайд нийт 6000 орчим хүн л тогтмол ажиллана. Өнөөдөр ханган нийлүүлэгчдийн ажиллагсдыг оруулвал монголын 45 мянган хүн энэ төсөлд хамрагдаж байна. Өмнөговь аймгийн өнгө төрх шинэчлэгдэж, нийт 400 сая долларын хөрөнгө оруулалт хийгдэж, Ханбогд сум гэхэд л орчин үеийн хот болох сууриа тавиад байна. Монголын олон мянган залуус мэргэжлийн хувьд олон улсын түвшинд мэргэшин дадлагажаад байна.

ОТ-н экспортлож буй баяжмалыг цэвэр зэсээр тооцвол жилд 160.000 тонн бөгөөд далд уурхайн

## АСУУДЛЫГ ӨНДРӨӨС ХАРВАЛ

ОТ бол монголын эдийн засгийг хөтөлгөч хамгийн том төсөл. Төслийг хэрэгжүүлэхийн тулд олон гэрээ байгуулж, шинэчилж ирлээ. Хөрөнгө оруулалтын, хувьцаа эзэмшлийн, гүний уурхайн, нэмэгдэл, дубайн гэрээ гэх мэт. Олон алдаа, дутагдал гарсан тухай УИХ-ын ажлын хэсгийн тайланд нэлээн нухацтай гаргаж тавьсныг тэмдэглэх хэрэгтэй.

Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ээ тохиролцоогүй байж хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, үр дүнд нь төслийн зардал анх тохирсноосоо хоёр дахин өсчихсөн, хөрөнгө оруулагч нь тэр зардлынхаа 3 хувиар менежментийн төлбөр авдаг, зардлын нэр томъёоны тухай нэгдсэн ойлголт байхгүй учир татварын маргаан үргэлж гардаг зэрэг олон асуудал, сорилтууд тулгарсаар байна. 2009-2015 оны хооронд 3.2 их наяд төгрөгийн татварын зөрчил гарсан гэж тус Ажлын хэсгийн тайланд оржээ.

Гэхдээ энэ бүхнийг хоёр тал ширээний ард сууж ярилцах, ойлголцох, засч залруулах хугацаа нөхцлөө урьдчилан тохирч ажиллах, дүгнэх замаар явж л харилцан итгэлцэл бий болно. Зөвхөн харилцан итгэлцэл тогтсон цагт л хамтын ажиллагаа өндөр өгөөжтэй, харилцан ашигтай болдог.

*Монголын тал эдүгээ том төслүүдэд хувьцаа эзэмшихийн оронд эхнээсээ татвар, төлбөрөө илүү аваад явах нь зөв гэж ярих боллоо. Энэ хувилбарыг одоо байгаа нөхцөлтэй харьцуулан судлах, 34 хувиа яаж үнэлэх, хэнд борлуулах, өрөндөө хэдийг нь суутгах, төслөөс авах татвар, төлбөрийн хувь хэмжээг яаж өөрчлөх зэргийг ярилцаж эхлэх хэрэгтэй байна.*

олборлолт эхэлсний дараа үйлдвэрлэл 3-4 дахин өснө. Тэгэхэд Монгол улсын төсвийн орлогын үлэмж хэсгийг ганц ОТ бүрдүүлэх гэнэ. Гэхдээ энэ төслийг тэр хүртэл нь явуулах эсэх нь яг одоо асуудал болоод байна. 2020 оны сонгууль ойртож төр засгийн эрх баригчдын “улс төрийн синдром” эхэлсэн учир энэ төслийн гэрээг засч сайжруулахаасаа илүү хүчингүй болгох, төслийг зогсоож “баатрын дүрээр” ялгарах сонирхол давамгайлж эхэллээ.

*Мэдээж, монголын түүхэн дэх хамгийн том, ардчилсан монголын барууны ертөнцтэй хийсэн анхны төсөл, Оросын мэргэжилтний зөвлөгөөгүй байгуулсан анхны гэрээ учир алдаж оносон зүйл их байгаа. Гэрээг байгуулсан сайд дарга нарыг ашиг сонирхлын зөрчил гаргасан гээд хорьж, шалгаж байцааж байна. Уул уурхайгаас хамааралтай хөгжиж буй буурай улсуудын нийтлэг зовлон монголд тохиогоод байна.*

Мөн энэ төсөлтэй холбоотой төр засгийн удирдагчид, улс төрчдийн шууд ба шууд бус ашиг сонирхлыг ил тод болгох талаар иргэний нийгэм идэвхтэй ажиллах шаардлагатай байна. Иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх замаар төслийн өгөөж нь монголын айл өрх бүрт илүү мэдрэгдэх болно. Зөвхөн энэ замаар л байгалийн баялаг нь хараал биш, ерөөл болдог.

Ийм том төслийн менежмент хийж, тэр олон том банкнаас зээл авсны хувьд Рио Тинто бүх талын баталгаа даатгал хийлгэхээс өөр сонголтгүй юм. ОТ-н гэрээнд өөрчлөлт оруулах, эсвэл гэрээнийхээ хүрээнд дээрх асуудлуудыг тодруулж, тодорхойлох шаардлага байгаа нь үнэн. Монголын талын өгөөжийг нэмэгдүүлэх талаар гэрээ хэлэлцээ хийхэд хөрөнгө оруулагч бэлэн гэж мэдэгдээд байгаа.

Тийм учраас ОТ төслийг дахиад л сонгуулийн шоу болгож биш, сонгуулийн дараа тогтон сууж, товлон ярилцах хэрэгтэй байна. Түүнээс биш зарим түшмэдийн саналаар гэрээгээ цуцлах аваас Монгол улсын хувьд “хөл рүүгээ буудсантай” адил юм. Энэ төслийг худалдан авахад бэлэн хөршүүд ч бий. Гуравдагч хөршүүд, тэдний зээл олгосон банкууд харин монголчууд гэрээгээр тохирсон ажлаа яаж хэрэгжүүлж буйг анхааралтай ажиглаж байгаа.

Барилгыг дуусахаар нь байшин гэдэг, харин дутуу бариад хаячихвал овоолго болдог. ОТ-гоо эхлээд байшин болгоё. Овоолго болгочихвол хариуцах эзэн ч алга болж, улс орон арбитрын шүүхийн зардлыг оруулаад баахан өртэй хоцорно.



НИЙТЛЭЛ

**Б.НАСАНБАЯР**  
Ph.D /Боловсрол судлал/

# Хүүхдийн хөгжилд ЭЦЭГ, ЭХ БИД...



*Бид үр хүүхдээ хүндлэн хайрлаж, бахархаж чаддаг эцэг, эхчүүд мөн үү?*

*Эцэг эхчүүд бид хичээл гэдгийг зөвхөн сургууль дээр л явагдах ёстой гэж боддог уу?*

*Хүүхэд хүн болох ухааныг өдөр тутмын гэр бүлийн амьдралын харилцаан дундаас суралцдаг гэдгийг та хүлээн зөвшөөрөх үү?*

*Эдгээр асуултуудыг аав ээж хэмээх хүндтэй нэр төр, үүрэг хүлээсэн та, бид өөрөө өөрөөсөө нэг асууж үзэхэд илүүдэхгүй байх.*

Хүн болох багаасаа. Бага насны хүүхдийг “хүн” болоход хамгийн их нөлөөлөх хүчин зүйл нь гэр бүлийн төлөвшил. Эцэг эхийн амьдралын өдөр тутмын хандлага, дүр зураг, хүнийг үнэлэх үнэлэмжээр хүүхдийн зүрх сэтгэл төлөвшдөг. Тереза эх “Таны зүрх сэтгэлийн хайр хаанаас эхэлдэг вэ?” гэсэн хэн нэгний асуултанд “Би гэр бүл дотроо амьдрах ухаан, хүнийг хайрлахыг суралцсан” гэж хариулсан байдаг. Хэдийгээр гоё сайхан орд харшид амьдарч, тансаг хэрэглээтэй байсан ч эцэг, эх хоёрын хоорондын харилцаа муу гэр бүлээс хүүхдэд сайн үлгэр дууриалал ирнэ гэж хэлэхэд хэцүү.

## ГЭР БҮЛ ИРЭЭДҮЙН ҮНДЭС

Эртнээс эцэг, эхийн хайр бол уулнаас өндөр, уснаас гүн гэж зүйрлэж ирсэн. Хүүхэд зөв сайн хүн болох, ирээдүйд хүмүүстэй найрсаг, аз жаргалтай амьдарч чадах уу үгүй юу гэдэг нь эцэг эх, хүүхдийн харилцаанаас шалтгаалах буюу бүх харилцааны суурь үндэс нь гэр бүлийн харилцаа байдаг.

Хүүхэд нь бүтэлгүйтэхэд эцэг, эх нь шууд л сургууль, багш нар, эсвэл хаа хамаагүй хэн нэгнийг буруутгадаг. Эсвэл энэ нийгмээс хүүхэд маань ийм болчихлоо гэдэг эцэг, эхчүүд ч байна. Нийгмийн байдал нь нөлөөлөх боловч хүүхдэд хамгийн их нөлөөлж чадах хүмүүс бол эцэг, эхчүүдээс өөр хэн ч биш юм.

Гэр бүлдээ бусдын бурууг олж харахаас илүү өөрийнхөө бурууг олж хардаг, өөрийнхөө сайн талыг бусдад мэдүүлэх гэж хичээхээс өмнө бусдын сайн талыг олж харахыг хичээдэг байх нь та үр хүүхдэдээ өвлүүлэх хамгийн том өв хөрөнгө. Энэ нь нэг л өдөр бий болчихдог зүйл биш, өдөр бүр бага багаар хуримтлуулдаг зүйл. Орчин үед гэр бүлийн үүрэг суларч, гэр бүлийн харилцаанд өөрчлөлт орж хүүхдийн хөгжлийн чухал орчныг бид өөрсдийн гараар устгаж үгүй

хийсээр байна. Гэтэл ихэнх хүмүүс одоогийн хүүхэд залуус болохоо больсон тухай ам уралдан ярьдаг.

**Эцэг, эхчүүд хүүхдэдээ хамгийн их хэлдэг үгийн жагсаалтын эхний байранд дараах гурван шаардлага орсон байна:**

- ◆ Хичээлээ давт
- ◆ Эрт унт
- ◆ Эрт бос

“Хичээлээ хий” гэж олон дахин үглэх нь хүүхдийн хичээл хийх хүслийг алга болгодог. Ялангуяа “Хичээлээ давт” гэдэг үгийг ээжүүдийн 90%, аавуудын 50% нь хэлдэг гэнэ. Гэвч энэ нь ихэвчлэн тодорхой үр дүнд хүрдэггүй. Хүүхдүүдийн саналыг сонсоход “хичээл хийх сонирхол огт үгүй болчихдог” гэж хэлсэн байхад дөнгөж 20% нь “хичээл хийхээс болохгүй нь дээ гэж боддог” гэж хариулсан байв. Эцэг, эхчүүдэд “Хүүхдийг зөнд нь орхичихвол хичээл хийнэ гэж ердөө ч байхгүй” гэсэн бодол байдаг. Гэвч үргэлжийн үглэлт яншилт, албадлага нь хүүхдэд сөргөөр нөлөөлдөг байна.

## ХҮҮХЭД БОЛ ХҮН

Хүн болгон л хүүхдээ төгөлдөр хуурын, зургийн, бүжгийн, жүжгийн гээд олон дугуйланд зэрэг зэрэг явуулж түүнийгээ бахархал болгох нь бий. Мэдээж хүүхэд нь ямар нэг юмыг бусдаас илүү өөртөө итгэлтэйгээр хийж чаддаг нь эцэг, эх хүний хүсэл мөрөөдөл байж болно. Энэ бүхнийг би үгүйсгэж байгаа юм биш. Гэхдээ хэтэрхий их ачаалал нь эргээд хүүхдэд сайнаар нөлөөлдөггүй гэдгийг л анхааруулах гэсэн юм. Хүүхэд, насанд хүрэгчдийн хэн ч ялгаагүй сэтгэл зүрхээрээ зөвшөөрч чадахгүй бол хүний хэлж буй үйлдлийг даган дуурайхад хэцүү байдаг. Сэтгэл зүрхээрээ зөвшөөрч чадвал, бие махбод аяндаа дагадаг.

Бид бараг бүгдээрээ хүүхдээ сайн сургуульд оруулж, олон хичээлийг нэртэй сайн багш нараар заалгачихвал ч хамаг хэрэг бүтлээ гэж боддог. Гэвч энэ нь зөвхөн өөрсдийнхөө хүслийг тэр бага балчир хүүхдэд тулган шаардсан явдал юм. Эцэг эхчүүд, багш нар бүх төрлийн мэдлэгийг хүүхдийн толгойд албаар “чихэн оруулахыг” хичээдэг. Ингэснээр хүүхэд хэзээ ч бие даасан байдалтай болж чадахгүй, мөн тэдний сэтгэн бодох, бүтээлч чадвар нь хөгжихөд саад үүсдэг.

Хүүхдийн зүрх сэтгэлийг үгүйсгэсэн сургалт, үйл ажиллагаа үр дүнд хүрдэггүй. Харин хүүхэд асуудал дунд өөрөө оржухамсартайгаар асуудлыг шийддэг болохын тулд тэднийг өөрөө оролцож,

хамтарч хийж турших, бүтээх боломж олгоход ямар ч хүнд агуулга, сэдэв хичээлийн учрыг олж чадна. Боловсролын утга учир нь олон төрлийн хичээлийг хүүхдэд тулган заах хэрэг огт биш харин тэднийг өөрийн үнэ цэнэ, хүсэл зорилгоо мэдэрч ойлгож, хамтран ажиллаж, амьдрахад суралцахад оршдог.

Хүүхдэд олон талын мэдлэг олгох нь чухал боловч түүнээс чухал нь хүнлэг сэтгэлтэй байх явдал юм. Энэ нь хүнийг аз жаргалтай амьдрах үндэс суурь болдог. Хүүхдийн хүнлэг сэтгэл нь ээж, аавын хайраас бүрэлдэн хөгждөг. Хүүхэд бусдын хайрыг мэдэрснээр бусдыг хайрлахын утга учрыг мэдэрч, аз жаргалтай байж өөрөө хичээх урам зоригтой болж, зөвхөн өөрийгөө бус бусдын тухай бодож чаддаг болно. Ийм хүүхдийг зөнд нь орхисон ч өөрөө өөрийгөө хөгжүүлж өөрийн зарчим, хуулийг бий болгодог.

Хүйтэн хөндий гэр бүл, орчноос хүүхдийн бүхий л ааш занд өөрчлөлт орж худлаа хэлж, арга заль хэрэглэх, хариуцлагаас яаж амархан мултрахаа бодож, бусдыг дарамталж, доромжилж, амин хувиа хичээсэн, өөрийнхөө төлөө бусдыг ашиглах гэсэн хүн болдог. Хүн бүхэн л хэзээд сэтгэл санааны дэмжлэг хүсч, үнэ цэнээ мэдрэхгүй бол ажиллах урам зориг гардаггүй шиг хүүхэд ч мөн адилхан.

## ХҮҮХДЭЭ МАГТАЖ БАЙЯ

Хүний сэтгэл гэдэг юуг хүлээж авч байснаас шалтгаалж хөгжил нь тодорхойлогддог. Хүүхдэд хэлэх үгээ их анхаарах хэрэгтэй. Хүүхдэдээ урам хайрлаж хүүхдээ магтдаг байя. Томчуудын хувьд дэмий зүйл байж магадгүй ч хүүхдийн хувьд их хичээл зүтгэл, ялалт болж хийсэн зүйлийг нь маш сайн магтах хэрэгтэй. Энэ үед таны хүүхдэд хийвэл чадах юм байна гэсэн өөртөө итгэх итгэл бий болдог.

“Нэг өдөр өөрсдөө ч мэдэлгүй манай хүүхэд гэж яаж ч болохгүй хүн байна” гэж хэлэх болдог. Гэвч сайн бодоод үзэхэд яаж ч болохгүй гэж бодож байгаа нь зөвхөн таны л бодол. Та өөрийнхөө бодлыг өөрчилвөл хүүхэд тань ч гэсэн өөрөөр харагдах болно.

Буруу зүйл хийсэн хүүхдийг ч гэсэн загнахгүй байх хэрэг үү гэж асуух хүн байдаг. Мэдээж буруу зүйл хийвэл зэмлэх хэрэгтэй. Гэвч зэмлэхдээ анхаарах нэг зүйл бол сайн талыг сануулангаа зэмлэх явдал байдаг. Загнуулж зэмлүүлсний дараа алдаагаа засч, тохиролцсон зүйлсээ хийж байвал магтаж өгөөрэй. Танаас уучлалт гуйх үед

хүүхдээ магтахад ямар их баярлах бол.

Хүн ер нь өөрийнхөө сул талыг хэлүүлээд тэр нь яг онож хэлсэн ч гэсэн дургүй нь хүрдэг. Мөн хүн магтуулахаар хүч чадал, итгэл урамтай болдог. Хүүхэд яг л бидэнтэй адилхан хүн. Хүүхдийнхээ сайн талыг олж харж, магтахад хүүхдийнхээ яриаг сайн сонсох нь чухал. Бидэнд хоёр чих, ганц ам байгаа нь бага ярьж их сонсох үүрэгтэйг санахад илүүдэхгүй.

Хүүхдийн төлөвшил, хүмүүжил гэхээр ихэнх хүмүүс зөвхөн эцэг эхээс үр хүүхдэдээ зааж зааварлах юм шиг өрөөсгөл ойлгодог. Хүүхдийнхээ төлөвшлийг эцэг, эхчүүд өөрсдийн харилцаа, хандлагаа эерэг болгож, хүүхдээ магтахаас эхлэх учиртай.

*“Боловсрол бол өөртөө итгэх итгэл. Өөртөө итгэлтэй байх нь хүсэл, найдварыг төрүүлдэг. Хүсэл мөрөөдөлтэй байх нь энх тайвныг дэлгэрцүүлнэ.” Күнз. (МЭӨ 551-479)*

2019 оны 6-р сар



## ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:  
2019.06.02-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

## ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ХОРИГ

### Үйл явдлын товч:

Хуулийн салбарынхан тэр чигээрээ эсэргүүцэж байсан Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 5-р сарын 9-нд их хурал баталчихсан. Харин энэ хуульд Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ дагуу бүхэлд нь хориг тавьчихлаа. Одоо их хурал хоригийг хүлээн авах эсэх асуудал анхаарал татаж байна.

### Дүгнэлт тайлбар:

2015 оны 6-р сарын 19-нд энэ хуулийг баталсан нь Захиргааны дур зоргыг хязгаарлаж, төрийн үйлчилгээ, шийдвэр гаргалтыг журамлаж иргэний эрхийг баталгаажуулсан дэвшил байсан гэж хуулийн салбарынхан үздэг. 2016 оны 7-р сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн энэ хуульд 2016 оны 12-р сарын 1; 2017 оны 5-р сарын 18; 2017 оны 12-р сарын 21; 2019 оны 3-р сарын 22; 2019 оны 4-р сарын 18-нд тус тус өөрчлөлт оруулсан. Эндээс асуулт гарч байгаа юм. УИХ-ын гишүүд хууль гаргахдаа сарын дараа өөрчилнө гэж гаргадаг юм уу? Үүний цаана эдгээр хүмүүс зөвхөн ойрын хугацаанд, өөрсдөдөө ашигтайгаар хууль хийж, улсын хөрөнгийг шамшигдуулах гэсэн бүлэг ажиллагаа явагдаж байна гэж харж байна.

### Захиргааны хуулийн одоогийн өөрчлөлтөөр:

- “Засгийн газрын шийдвэр” төдийгүй “түүнийг хэрэгжүүлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа” захиргааны хэргийн шүүхийн хяналтаас бүрэн гарна.
- Засгийн газраас бус байгууллага, албан тушаалтан (Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг)-ны улс төрийн үйл ажиллагааг захиргааны үйл ажиллагаанаас заагласан ялгаа алга болж тодорхойгүй байдал үүснэ. Үүний үр дагаварт хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн суурь үнэт зүйлс болсон хууль дээдлэх зарчим, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүллгэх, хөндөгдсөн эрхээ сэргээлгэх эрхүүд Засгийн газрын шийдвэр болон түүнийг биелүүлэхтэй холбоотой харилцаанд хэрэгжих боломжгүй болно.

Шийдвэр гаргагчид аль болох иргэдийн хяналтаас холдохыг эрмэлзэж байна гэж харж байна. Ерөнхийлөгчийн энэ хоригийг хүлээж авахгүй буюу нэг нь гав хийсэн болоод нөгөө нь гов хийсэн болоод өнгөрөх байх.

 **WORLD WINE**  
Prosecco Bar



**1 давхар, БУДДА виста**  
**Утас: 7777-4747**

## НАЙРАМДАЛ ЗУСЛАНГИЙН ГАЗАРТ “НАЙРЛАСАН” НЬ

Үйл явдлын товч:

Улаанбаатар хотын газрын хулгай, наймааны асуудал Зайсан, Яармаг гэсэн хэсгээр яригддаг байсан бол Найрамдал зуслангийн орчмоор хүрээгээ тэлж байна. НИТХ 2009 онд тогтоол гарган цогцолборын тусгай хэрэгцээнд байсан 5220 га газрын 1220 га-г нь “Найрамдал” цогцолборт 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үлдсэн 4000 га газрыг иргэд, аж ахуйн нэгжийн өмчлөлд өгсөөр байгаа нь цогцолборын үйл ажиллагаа доголдох, хүүхдүүдийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлдэг үр дагавартай гэж үзэн газрын зөвшөөрлүүдийг судлаж, ямар арга хэмжээ авах саналаа Засгийн газарт танилцуулах, шинээр газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан, сайд С.Чинзориг нарт даалгасан. Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор орчмын тусгай хэрэгцээнд байсан газрыг 100-аад иргэн, аж ахуйн нэгж авчихсан байгаа ба хууль бусаар олгосон нэр бүхий 64 аж ахуй нэгж, иргэдийн газар эзэмших эрхийг цуцлах шийдвэрийг хотын дарга гаргачихлаа.

Дүгнэлт тайлбар:

Төрд гарсан хүмүүс нийтийн эзэмшлийн газрыг зарж, баяжиж дууслаа даа. Энэ Засгийн газар үүнийг зогсооно, хотын дарга эрхийг нь цуцаллаа л гэж байна. Гэхдээ дэндүү оройтсон ажил болж байна гэж харж байна.

Л.Оюун-Эрдэнэ “АСЕМ нэрээр хэдэн авлигач нийлээд Их тэнгэрийн аманд газартай болсон” гэж хэлсэн. Их тэнгэрийн амыг хүртэл зарж болж байна шүү дээ. Нэг өдөр Сүхбаатарын талбайг зарчихсан байх вий.

2008 оноос 2012 он хүртэл хотын даргаар Г.Мөнхбаяр, 2012 оноос 2016 онд Э.Бат-Үүл, 2016 оноос Су.Батболд гэж хүн байж байгаад солигдлоо шүү дээ. Сүүлчийнх нь газрыг Су.Батболд өгсөн байгаа гэж байгаа. Мөн Э.Бат-Үүл зөндөө газар өгсөн түүний дотор намынхаа дарга С.Эрдэнэд газар өгсөн.

Бусад оронд бол газар хөгжлийн суурь, хаана газар эзэнтэй тэнд л хариуцлагатай байдаг. Иргэд нийтийн сонирхлынхоо төлөө дугардаггүйн хор уршиг нь энэ. Түүнээс биш энэ бүх хулгайг хараагүй, сонсоогүй хүн байхгүй шүү дээ.

**НИСЛЭГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАЛ**

2016 оны 06 сарын 22 өдөр

Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн талбайн хэмжээ, зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний иргэдийн тухай хуулийн 29 дугаар зүйлийн 2.2, 3 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3, 2.4 д-аар заалт, Газрын харилцаа тусгай зүйлс газрын даргын 2009 оны 83 дугаар “Газар эзэмшүүлэх, ашиглах эрхийн гэрээгээр олгох журам”, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 01/4 дугаар тогтоолоор баталсан “Газар эзэмшүүлэх, ашиглах эрхийн гэрээгээр олгох журам” гэдэг зориулалтын өөрчлөх үйл ажиллагааг хурмагч тус тус үндэстэн ЗАХИРАМЖИХАА

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт газар, барилгын тусгай зориулалт хэлбэрээр чиг үүрэг бүхий “Газар, барилгын тусгай зориулалтын” үйлдлийн тухай хуулийн 29 дугаар зүйлийн 2.2, 3 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3, 2.4 д-аар заалт, Газрын харилцаа тусгай зүйлс газрын даргын 2009 оны 83 дугаар “Газар эзэмшүүлэх, ашиглах эрхийн гэрээгээр олгох журам”, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 01/4 дугаар тогтоолоор баталсан “Газар эзэмшүүлэх, ашиглах эрхийн гэрээгээр олгох журам” гэдэг зориулалтын өөрчлөх үйл ажиллагааг хурмагч тус тус үндэстэн ЗАХИРАМЖИХАА
2. Газар эзэмшүүлэх, ашиглах эрх нь баталгаажигдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдох хууль тогтоомж, журмын дагуу гэрээ байгуулж, гэрээгээр олгох, хэрэгжигдэх эхлэлт тавьж ажиллагааг нийслэлийн Өмчийн харилцааны газар ЛШ.Төмөрбайртай дамжуулж.
3. Энэ захирамж гарсантай холбогдолгүй талбайн хэмжээ, зориулалт өөрчлөгдсөн нийслэлийн Засаг даргын 2011 оны 952 дугаар захирамжийн Сидарсүрэнрөө ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/37 дугаар захирамжийн Арин-Онар ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/28 дугаар захирамжийн Минх-Отгон сондор ХХК, Ц.Мөнхтөр, Л.Гантөмөр, Б.Давдасүрэн, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/55 дугаар захирамжийн иргэн Г.Мөнхсанзид, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/52 дугаар захирамжийн иргэн Л.Тунгалт, нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1050 дугаар захирамжийн Богда хоолой ХХК-д, 2 заалт, нийслэлийн Засаг даргын 2003 оны 248 дугаар захирамжийн иргэн Л.Хэсэйдэнд, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/268 дугаар захирамжийн иргэн Э.Мөнхсайхан, М.Өлзийтэнд, нийслэлийн Засаг даргын 2014 оны А/250 дугаар захирамжийн иргэн Н.Мөнхтөгөд, нийслэлийн Засаг даргын 2011 оны 200 дугаар захирамжийн иргэн С.Хандуур, М.Отгонбат,

2

нийслэлийн Засаг даргын 2004 оны 380 дугаар захирамжийн иргэн Ц.Сонжсүрэнд, нийслэлийн Засаг даргын 2011 нийслэлийн Засаг даргын 2011 дүрэн 2016 оны А/207 дугаар захирамжийн иргэн Ч.Амгалаг, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/158 дугаар захирамжийн Давшанзиг ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/231 дугаар захирамжийн иргэн А.Оюунчимт, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/207 дугаар захирамжийн иргэн Ш.Баттүвшид, нийслэлийн Засаг даргын 2011 оны 312 дугаар захирамжийн Насзах интернационал ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/452 дугаар захирамжийн иргэн Ц.Давдасүрэн, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/555 дугаар захирамжийн иргэн Ц.Давдасүрэн, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/330 дугаар захирамжийн Н.Бургаданд, нийслэлийн Засаг даргын 2013 оны А/505 дугаар захирамжийн Хяар нуруу ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/442 дугаар захирамжийн Алтан могой илбээ ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2014 оны А/514 дугаар захирамжийн иргэн М.Батсүх, нийслэлийн Засаг даргын 2001 оны 308 дугаар захирамжийн Хаягуу ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2004 оны 455 дугаар захирамжийн Залуу могой ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2011 оны 729 дугаар захирамжийн иргэн А.Бат-Эрдэнэ, нийслэлийн Засаг даргын 2012 оны А/116 дугаар захирамжийн иргэн Р.Мандуул, нийслэлийн Засаг даргын 2003 оны 485 дугаар захирамжийн Маршалл төлөвлөгчийн үндэстэн перлад, нийслэлийн Засаг даргын 2014 оны А/1015 дугаар захирамжийн Сүхбаатар дүүргийн Засаг захиргааны Тасралтгүй ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/245 дугаар захирамжийн Эвмэгт ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/53 дугаар захирамжийн Рамал сан ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2004 оны А/184 дугаар захирамжийн Хан-Уул дүүргийн Солонгос ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2013 оны А/884 дугаар захирамжийн иргэн Ч.Наруул, нийслэлийн Засаг даргын 2012 оны А/40 дугаар захирамжийн Монре констракшн ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2014 оны А/209 дугаар захирамжийн Эвмэгт ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/209 дугаар захирамжийн Зорба интернационал дистрибушн ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2011 оны 781 дугаар захирамжийн иргэн Н.Наруул, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/317 дугаар захирамжийн Буяа ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2014 оны А/917 дугаар захирамжийн иргэн Т.Гуушмэгэрт, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/1300 дугаар захирамжийн Ган солонгос ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/442 дугаар захирамжийн Шэнэ орлогч мэд ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2014 оны А/500 дугаар захирамжийн Ил бэлэн ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2018 оны А/262 дугаар захирамжийн Жайбе вантуур ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/282 дугаар захирамжийн Энэ констракшн ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2008 оны А/1051 дугаар захирамжийн Эн Эн Эл Эл ХХК-д, нийслэлийн Засаг даргын 2011 оны 818 дугаар захирамжийн иргэн Л.Сонгойд, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/238 дугаар захирамжийн Давшанзиг ХХК, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/280 дугаар захирамжийн Мөнгөн ХХК-д тус тус захирагч захиргааг хүчинтэй болгож тооцгооно.

НИСЛЭГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАЛ

Э.БАТ-ҮҮЛ

Олон улсын хуулийн “Найрамдал” тусламжийн орчмын газар эзэмшүүлэх, ашиглах эрх

ИД	Огноо	Нэр	Регистр	Нэгж талбарын дугаар	Талбайн хэмжээ (м <sup>2</sup> )	Засрагч, өмчлөгч	Иргэдийн төлөөлөгчийн хурлын шийдвэр	Баталгааны эрх	Баталгааны тус
1	Байгууллага	УСГТгаар	2117568	1802021130983	10435	НЗД-н 2013 оны А/30		Цэвэр усны өвсө стэн	
2	Байгууллага	УСГТгаар	2117568	1802021228903	654	НЗД-н 2013 оны А/30		хуаг	
3	Байгууллага	УСГТгаар	2117568	1802021163400	1116	НЗД-н 2013 оны А/30		хуаг	
4	Байгууллага	УСГТгаар	2117568	1802021356716	7389	НЗД-н 2013 оны А/30		3-н гууны хуаг	
5	Байгууллага	УСГТгаар	2117568	1802021130200	989	НЗД-н 2013 оны А/30		хуаг	
6	Байгууллага	УСГТ-Хуаг	2117568	1802020018476	7363	НЗД-н 2013 оны А/30		хуаг	
					27296				

ИД	Огноо	Нэр	Регистр	Нэгж талбарын дугаар	Талбайн хэмжээ (м <sup>2</sup> )	Засрагч, өмчлөгч	Иргэдийн төлөөлөгчийн хурлын шийдвэр	Баталгааны эрх	Баталгааны тус
1	Байгууллага	Пьэрэ ХХК	5184347	1802022223283	700	НЗД-н 2016 оны А/44		Баруун Сүхбаатар	4
2	Байгууллага	Пьэрэ ХХК	5184347	1802022233309	700	НЗД-н 2016 оны А/44		Баруун Сүхбаатар	4
3	Дамчир	Ганболд	045504201	1802022394504	200	НЗД-н 2016 оны А/44		Байсанхай 58	1
4	Чулуусчир	Сүхбаатар	18074053076	1802022309644	700	НЗД-н 2016 оны А/263		Байсанхай	1
5	Баясан-Оюун	Отгонбаяр	0386041065	1802022304549	1317	НЗД-н 2016 оны А/263		НЗД-н 2016 оны А/266	Байсанхай
6	Дамчир	Сайрагч	0800501989	1802022376512	400	НЗД-н 2016 оны А/263		НЗД-н 2016 оны А/266	Байсанхай
7	Баян	Отгонбат	0074021214	1802022358426	700	НЗД-н 2016 оны А/263		НЗД-н 2016 оны А/266	Байсанхай
8	Далантай	Гантөмөр	0478002373	1802022468485	1861	НЗД-н 2016 оны А/263		НЗД-н 2016 оны А/266	Байсанхай
9	Номсод	Бургад	0786559913	1802022305029	1563	НЗД-н 2016 оны А/263		НЗД-н 2016 оны А/266	Байсанхай 20
10	Цул	Давдасүрэн	0397759711	1802022309239	2637	НЗД-н 2016 оны А/263		НЗД-н 2016 оны А/266	Байсанхай 20
11	Ганууч	Лавсансүрэн	0073014078	1802022426407	912	НЗД-н 2016 оны А/263		НЗД-н 2016 оны А/266	Байсанхай 1

Газар дээрээ хамтаат болж хоолой нэгж талбарууд байдаг

ИД	Огноо	Нэр	Регистр	Нэгж талбарын дугаар	Талбайн хэмжээ (м <sup>2</sup> )	Засрагч, өмчлөгч	Иргэдийн төлөөлөгчийн хурлын шийдвэр	Баталгааны эрх	Баталгааны тус
1	Дадан	Аюулар	0270110811	1802022020621	20962	НЗД-н 2014 оны А/202		НЗД-н 2016 оны А/170	
2	Номсод	Бургад	0786559913	1802022473130	1000	НЗД-н 2016 оны А/263		НЗД-н 2016 оны А/266	
3	Жаргалсайхан	Дорнод	1380201405	1802022319787	700	НЗД-н 2016 оны А/263		НЗД-н 2016 оны А/266	

GOOGLE STORE      APP STORE



Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв  
Тоймын бүрэн эхийг [jargaldefacto.com](http://jargaldefacto.com) вебсайтаас үзэх боломжтой.